



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 04 сарын 23 өдөр

Дугаар А/165

Мандалговь

Улсын цолтой аймгийн уугуул бөхчүүдэд  
хүндэтгэл үзүүлэх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 (а), Биеийн тамир спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.3, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.6 дахь заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2019 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн 7 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. XX зууны Төр нийгмийн зүтгэлтэн, Морьт отрядын жанжин, Хошууч генерал, Монгол Улсын заан Чимэдийн Мижидийн Монгол Улсын заан цолонд хүндэтгэл үзүүлэх улс, аймгийн алдар цолтой хүчит бөхийн барилдаан болохтой холбогдуулан улсын цолтой аймгийн уугуул бөхчүүдэд хүндэтгэл үзүүлсүгэй.

Хоёр. Хүндэтгэл үзүүлэх зардлыг хавсралтаар баталсугай.

Гурав. Хүндэтгэлийн зардалд 1200000 (Нэг сая хоёр зуун мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Эрдэнэсүрэн), нягтлан бодогч (Д.Нандинцэцэг) нарт зөвшөөрсүгэй

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

438190455

Аймгийн Засаг даргын 2019 оны 4 дүгээр сарын  
23-ны өдрийн 165 тоот захирамжийн хавсралт



ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЭХ ЗАРДЛЫН ТӨСӨВ

№	Овог, нэр	Алдар цол	Нэг хүнд олгох дэмжлэгийн хэмжээ /төгрөг/	БҮГД
1	Л.Пүрэвжав	Улсын харцага	200000	200000
2	Э.Даш	Улсын начин	200000	200000
3	Б.Чинзориг	Улсын начин	200000	200000
4	Ц.Улаанхүү	Улсын начин	200000	200000
5	А.Алтанхуяг	Улсын начин	200000	200000
6	Г.Олзгэрэл	Улсын начин	200000	200000
	ДҮН			1200000